ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/091/НА-СТА-ТШЗ


Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа

Утас: 90088028

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан....13

4.1 Ерөнхий зүйл ....13

4.2 Материаллаг байдал ....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16

5. Аудитын илрүүлэлт ....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл
**16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.01.28 № 42

танай________________-ны №__________________-т

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА С.НЯМЖАВ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 2,120.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 10.5 сая төгрөгийн, 8.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгаж 2,181.4 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант жилд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ тусгасан ба төлөвлөгөөний биелэлт 82.6 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *төгрөгөөр*

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 33,882,661.19 | 32,020,816.50 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 396,832.00 | - |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 396,832.00 | - |
| 31210 | Төгрөг | 396,832.00 | - |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 396,832.00 | - |
| 33 | АВЛАГА | 4,762,737.69 | - |
| 33500 | Бусад авлага | 4,762,737.69 | - |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 278,034.17 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,484,703.52 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 28,723,091.50 | 32,020,816.50 |
| 35400 | Хангамжийн материал | 28,723,091.50 | 32,020,816.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 547,100.00 | 45,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,605,396.00 | 30,063,896.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 571,000.00 | 1,113,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 999,595.50 | 798,420.50 |
| 3695 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 309,846,908.77 | 265,605,503.18 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 309,846,908.77 | 265,605,503.18 |
| 39200 | Биет хөрөнгө | 300,576,908.77 | 256,335,503.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 296,775,027.66 | 296,775,027.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (142,365,747.15) | (155,311,333.23) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 10,470,000.00 | 10,470,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (2,617,500.00) | (4,580,625.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 193,631,290.00 | 197,752,232.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (110,456,639.61) | (133,837,632.46) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 123,923,440.00 | 120,224,710.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (68,782,962.13) | (75,156,875.79) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 9,270,000.00 | 9,270,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,270,000.00 | 9,270,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 395 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 343,729,569.96 | 297,626,319.68 |
| 40 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 0.47 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 0.47 |
| 41300 | Өглөг | - | 0.47 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 0.47 |
| 50 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 343,729,569.96 | 297,626,319.21 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 343,729,569.96 | 297,626,319.21 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 283,902,924.82 | 283,902,924.82 |
| 51100 1 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 283,902,924.82 | 283,902,924.82 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 22,258,462.55 | (23,844,788:20) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 22,258,462.55 | 17,773,759.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (41,618,547.23) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 37,568,182.59 | 37,568,182.59 |
| 60 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 343,729,569.96 | 297,626,319.68 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,460,338,097.26 | 2,139,877,928.00 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,529,506.14 | 8,602,128.00 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 2,529,506.14 | 8,602,128.00 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,529,506.14 | 8,602,128.00 |
| 5 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,529,506.14 | 7,258,828.00 |
| 6 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 1,343,300.00 |
| 7 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,457,808,591.12 | 2,131,275,800.00 |
| 8 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,487,939.12 | 10,541,300.00 |
| 9 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| 10 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,487,939.12 | 10,541,300.00 |
| 11 | Төсвийн захирагчдаас | 3,368,752.00 | 2,120,734,500.00 |
| 12 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,120,734,500.00 |
| 13 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,368,752.00 | - |
| 14 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 1,443,951,900.00 | - |
| 15 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,443,951,900.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 16 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,524,193,097.65 | 2,181,496,475.23 |
| 17 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,524,193,097.65 | 2,181,496,475.23 |
| 18 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,450,696,688.84 | 1,780,800,582.42 |
| 19 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,095,817,276.54 | 1,432,753,194.34 |
| 20 | Үндсэн цалин | 653,362,714.83 | 820,096,793.34 |
| 21 | Нэмэгдэл | 288,414,782.92 | 410,504,087.52 |
| 22 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,181,998.74 | 60,263,202.50 |
| 23 | Урамшуулал | 112,857,780.05 | 141,889,110.98 |
| 24 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 137,216,540.79 | 176,460,483.09 |
| 25 | Тэтгэврийн даатгал | 94,086,037.93 | 122,626,390.99 |
| 26 | Тэтгэмжийн даатгал | 9,941,173.17 | 14,346,344.74 |
| 27 | ҮОМШӨ-ний даатгал | 8,834,119.33 | 7,149,217.56 |
| 28 | Ажилгүйдлийн даатгал | 2,094,967.29 | 6,390,053.23 |
| 29 | Эрүүл мэндийн даатгал | 22,260,243.07 | 25,948,476.57 |
| 30 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,449,489.77 | 49,105,587.81 |
| 31 | Гэрэл, цахилгаан | 3,749,753.77 | 4,136,591.81 |
| 32 | Түлш, халаалт | 36,387,296.00 | 42,539,356.00 |
| 33 | Цэвэр, бохир ус | 1,312,440.00 | 2,429,640.00 |
| 34 | Хангамж, бараа материалын зардал | 32,999,763.20 | 18,034,892.59 |
| 35 | Бичиг хэрэг | 14,486,600.00 | 8,950,540.00 |
| 36 | Тээвэр, шатахуун | 10,246,500.00 | 3,500,000.00 |
| 37 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,564,813.20 | 2,429,942.59 |
| 38 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 387,500.00 | 399,000.00 |
| 39 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,314,350.00 | 2,755,410.00 |
| 40 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,438,387.12 | 9,350,000.00 |
| 41 | Багаж, техник, хэрэгсэл | 1,405,400.00 | - |
| 42 | Урсгал засвар | 36,032,987.12 | 9,350,000.00 |
| 43 | Томилолт, зочны зардал | 11,432,200.00 | 26,638,400.00 |
| 44 | Дотоод албан томилолт | 11,432,200.00 | 26,638,400.00 |
| 45 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,329,780.00 | 5,299,291.00 |
| 46 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,629,300.00 | 2,778,500.00 |
| 47 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 864,000.00 |
| 48 | Даатгалын үйлчилгээ | 396,000.00 | 396,000.00 |
| 49 | Тээврийн хэрэгслийн татвар | 47,082.00 | 47,082.00 |
| 50 | Газрын төлбөр | 34,506.00 | 208,314.00 |
| 51 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 32,310.00 | 2,920.00 |
| 52 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,190,582.00 | 1,002,475.00 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,013,251.42 | 63,158,733.59 |
| 54 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 689,600.00 | 1,863,900.00 |
| 55 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,323,651.42 | 61,294,833.59 |
| 56 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 73,496,408.81 | 400,695,892.81 |
| 57 | Бусад урсгал шилжүүлэг | 9,400,800.00 | 261,799,352.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 58 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,400,800.00 | 11,057,000.00 |
| 59 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 75,597,467.33 |
| 60 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 175,144,885.00 |
| 61 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 138,896,540.48 |
| 62 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 138,896,540.48 |
| 63 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 64,095,608.81 | - |
| 64 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,095,608.81 | - |
| 65 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II) | (63,855,000.39) | (41,618,547.23) |
| 66 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (63,855,000.39) | (41,618,547.23) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО | 1,476,834,295.80 | 2,131,275,800.00 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 22,394,456.68 | - |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 22,394,456.68 | - |
| 4 | Бусад орлого | 22,394,456.68 | - |
| 5 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,454,439,839.12 | 2,131,275,800.00 |
| 6 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,487,939.12 | 10,541,300.00 |
| 7 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| 8 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,487,939.12 | 10,541,300.00 |
| 9 | Төсвийн захирагчдаас | - | 2,120,734,500.00 |
| 10 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,120,734,500.00 |
| 11 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 1,443,951,900.00 | - |
| 12 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,443,951,900.00 | - |
| 13 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,476,172,777.30 | 2,121,878,032.00 |
| 14 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,476,172,777.30 | 2,121,878,032.00 |
| 15 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,403,657,886.99 | 1,721,182,139.19 |
| 16 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,095,817,276.54 | 1,432,753,193.87 |
| 17 | Үндсэн цалин | 653,362,714.83 | 820,096,792.87 |
| 18 | Нэмэгдэл | 288,414,782.92 | 410,504,087.52 |
| 19 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,181,998.74 | 60,263,202.50 |
| 20 | Урамшуулал | 112,857,780.05 | 141,889,110.98 |
| 21 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 137,376,815.68 | 176,182,448.92 |
| 22 | Тэтгэврийн даатгал | 94,086,037.93 | 122,626,390.99 |
| 23 | Тэтгэмжийн даатгал | 10,139,505.55 | 14,148,012.36 |
| 24 | ҮОМШӨ-ний даатгал | 8,834,119.33 | 7,149,217.56 |
| 25 | Ажилгүйдлийн даатгал | 2,094,967.29 | 6,390,053.23 |
| 26 | Эрүүл мэндийн даатгал | 22,222,185.58 | 25,868,774.78 |

| | | | |
|---|---|---|---|
| 27 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,449,489.77 | 49,105,587.81 |
| 28 | Гэрэл, цахилгаан | 3,749,753.77 | 4,136,591.81 |
| 29 | Түлш, халаалт | 36,387,296.00 | 42,539,356.00 |
| 30 | Цэвэр, бохир ус | 1,312,440.00 | 2,429,640.00 |
| 31 | Хангамж, бараа материалын зардал | 44,911,863.20 | 20,991,792.59 |
| 32 | Бичиг хэрэг | 13,437,100.00 | 8,448,940.00 |
| 33 | Тээвэр, шатахуун | 10,246,500.00 | 3,500,000.00 |
| 34 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,564,813.20 | 2,429,942.59 |
| 35 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 387,500.00 | 399,000.00 |
| 36 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,275,950.00 | 6,213,910.00 |
| 37 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,438,387.12 | 9,350,000.00 |
| 38 | Багаж, техник, хэрэгсэл | 1,405,400.00 | - |
| 39 | Урсгал засвар | 36,032,987.12 | 9,350,000.00 |
| 40 | Томилолт, зочны зардал | 11,432,200.00 | 26,638,400.00 |
| 41 | Дотоод албан томилолт | 11,432,200.00 | 26,638,400.00 |
| 42 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,147,798.00 | 4,296,816.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,637,900.00 | 2,778,500.00 |
| 44 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 864,000.00 |
| 45 | Даатгалын үйлчилгээ | 396,000.00 | 396,000.00 |
| 46 | Тээврийн хэрэгслийн татвар | 47,082.00 | 47,082.00 |
| 47 | Газрын төлбөр | 34,506.00 | 208,314.00 |
| 48 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 32,310.00 | 2,920.00 |
| 49 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,084,056.68 | 1,863,900.00 |
| 50 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,394,456.68 | - |
| 51 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 689,600.00 | 1,863,900.00 |
| 52 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,514,890.31 | 400,695,892.81 |
| 53 | Бусад урсгал шилжүүлэг | 9,400,800.00 | 261,799,352.33 |
| 54 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,400,800.00 | 11,057,000.00 |
| 55 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 75,597,467.33 |
| 56 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 175,144,885.00 |
| 57 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 138,896,540.48 |
| 58 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 138,896,540.48 |
| 59 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 63,114,090.31 | - |
| 60 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 63,114,090.31 | - |
| 61 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 661,518.50 | 9,397,768.00 |
| 62 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ | - | 9,794,600.00 |
| 63 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 9,794,600.00 |
| 64 | Дотоод эх үүсвэрээр | - | 9,794,600.00 |
| 65 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 9,794,600.00 |
| 66 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | (9,794,600.00) |
| 67 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 661,518.50 | (396,832.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 68 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 716,832.00 | 396,832.00 |
| 69 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 396,832.00 | - |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *//төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 283,902,924.82 | 37,568,182.59 | 86,547,214.94 | 408,018,322.35 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 283,902,924.82 | 37,568,182.59 | 86,547,214.94 | 408,018,322.35 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | - | - | (64,288,752.39) | (64,288,752.39) |
| 4 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 283,902,924.82 | 37,568,182.59 | 22,258,462.55 | 343,729,569.96 |
| 5 | 2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 283,902,924.82 | 37,568,182.59 | 22,258,462.55 | 343,729,569.96 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (4,484,703.52) | (4,484,703.52) |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 283,902,924.82 | 37,568,182.59 | 17,773,759.03 | 339,244,866.44 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | - | - | (41,618,547.23) | (41,618,547.23) |
| **9** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **283,902,924.82** | **37,568,182.59** | **(23,844,788.20)** | **297,626,319.21** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэлийн зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,120,734,500.00 | 1,981,837,959.52 | 138,896,540.48 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,120,734,500.00 | 1,981,837,959.52 | 138,896,540.48 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,857,642,300.00 | 1,720,435,439.19 | 137,206,860.81 |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,539,408,000.00 | 1,432,753,193.87 | 106,654,806.13 |
| 5 | Үндсэн цалин | 837,204,900.00 | 820,096,792.87 | 17,108,107.13 |
| 6 | Нэмэгдэл | 456,344,000.00 | 410,504,087.52 | 45,839,912.48 |
| 7 | Унаа хоолны хөнгөлөлт | 75,196,000.00 | 60,263,202.50 | 14,932,797.50 |
| 8 | Урамшуулал | 170,663,100.00 | 141,889,110.98 | 28,773,989.02 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 193,980,300.00 | 176,182,448.92 | 17,797,851.08 |
| 10 | Тэтгэврийн даатгал | 133,688,500.00 | 122,626,390.99 | 11,062,109.01 |
| 11 | Тэтгэмжийн даатгал | 15,072,900.00 | 14,148,012.36 | 924,887.64 |
| 12 | ҮОМШӨ-ний даатгал | 7,536,500.00 | 7,149,217.56 | 387,282.44 |
| 13 | Ажилгүйдлийн даатгал | 7,536,500.00 | 6,390,053.23 | 1,146,446.77 |
| 14 | Эрүүл мэндийн даатгал | 30,145,900.00 | 25,868,774.78 | 4,277,125.22 |
| 15 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 55,430,600.00 | 49,105,587.81 | 6,325,012.19 |
| 16 | Гэрэл, цахилгаан | 7,455,300.00 | 4,136,591.81 | 3,318,708.19 |
| 17 | Түлш, халаалт | 45,383,500.00 | 42,539,356.00 | 2,844,144.00 |
| 18 | Цэвэр, бохир ус | 2,591,800.00 | 2,429,640.00 | 162,160.00 |
| 19 | Хангамж, бараа материалын зардал | 21,646,300.00 | 20,991,792.59 | 654,507.41 |
| 20 | Бичиг хэрэг | 8,456,000.00 | 8,448,940.00 | 7,060.00 |
| 21 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 3,500,000.00 | - |
| 22 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,687,000.00 | 2,429,942.59 | 257,057.41 |
| 23 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 399,000.00 | 399,000.00 | - |
| 24 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,604,300.00 | 6,213,910.00 | 390,390.00 |
| 25 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,350,000.00 | 19,144,600.00 | 205,400.00 |
| 26 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 9,794,600.00 | 205,400.00 |
| 27 | Урсгал засвар | 9,350,000.00 | 9,350,000.00 | - |
| 28 | Томилолт, зочны зардал | 17,367,600.00 | 16,097,100.00 | 1,270,500.00 |
| 29 | Дотоод албан томилолт | 17,367,600.00 | 16,097,100.00 | 1,270,500.00 |
| 30 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,595,600.00 | 4,296,816.00 | 4,298,784.00 |
| 31 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,743,200.00 | 2,778,500.00 | 3,964,700.00 |
| 32 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 | - |
| 33 | Даатгалын үйлчилгээ | 588,600.00 | 396,000.00 | 192,600.00 |
| 34 | Тээврийн хэрэгслийн татвар | 98,100.00 | 47,082.00 | 51,018.00 |
| 35 | Газрын төлбөр | 208,500.00 | 208,314.00 | 186.00 |
| 36 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 93,200.00 | 2,920.00 | 90,280.00 |
| 37 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,863,900.00 | 1,863,900.00 | - |
| 38 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,863,900.00 | 1,863,900.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 39 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 263,092,200.00 | 261,402,520.33 | 1,689,679.67 |
| 40 | Бусад урсгал шилжүүлэг | 263,092,200.00 | 261,402,520.33 | 1,689,679.67 |
| 41 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,660,300.00 | 10,660,168.00 | 132.00 |
| 42 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 77,287,000.00 | 75,597,467.33 | 1,689,532.67 |
| 43 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 175,144,900.00 | 175,144,885.00 | 15.00 |
| 44 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,120,734,500.00 | 1,981,837,959.52 | 138,896,540.48 |
| 45 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,120,734,500.00 | 1,981,837,959.52 | 138,896,540.48 |
| 46 | Улсын төсвөөс санхүүжих | 2,120,734,500.00 | 1,981,837,959.52 | 138,896,540.48 |
| 47 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 101.00 | 91.00 | 10.00 |
| 48 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - |
| 49 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - |
| 50 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 50.00 | 45.00 | 5.00 |
| 51 | Удирдах ажилтан | 5.00 | 5.00 | - |
| 52 | Гүйцэтгэх ажилтан | 42.00 | 37.00 | 5.00 |
| 53 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | - |
| 54 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 50.00 | 45.00 | 5.00 |
| 55 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 44.00 | 40.00 | 4.00 |
| 56 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 5.00 | 1.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|
| **1** | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | **10,541,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,541,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,541,300.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,541,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,541,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,541,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,541,300.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **10,541,300.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,541,300.00 |

## 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын зорилго:* Бид даатгуулагчийнхаа иттэл, найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Нийгмийн даатгалын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
4. Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тухай хууль
6. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
7. Төсвийн тухай хууль
8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Нийгмийн даатгалын хэлтэс нь 2024 оноос Нийгмийн даатгалын газар болсонтой холбоотойгоор Хяналт, шалгалтын тасаг нь Захиргаа, хяналтын хэлтэс болж өөрчлөгдөн 9 байцаагч, ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнээс нийгмийн хамгааллын улсын байцаагч 1, хяналт шалгалтын улсын байцаагч 1 ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил, гүйлгээнд газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх иттэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 41,618.5 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 396.8 | 0 | 396.8 |
| Авлага | 4,762.7 | 0 | -4762.7 |
| Бараа материал | 28,723.1 | 32,020.8 | 3,297.7 |
| Үндсэн хөрөнгө | 309,846.9 | 265,605.5 | 44,241.4 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **343,729.5** | **302,111.0** | **41,618.5** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **343,729.5** | **302,111.0** | **41,618.5** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **343,729.5** | **302,111.0** | **41,618.5** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 4,762.7 мянган төгрөг байсан бөгөөд өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу барагдуулах ажлыг зохион байгуулсан боловч хариуцагчгүй болсон нь нотлогдсон тул данснаас хассан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 28,723.1 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 21,848.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, НДЕГ-аас үнэ төлбөргүйгээр ирсэн 1,343.3 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэн, 19,894.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар, эцсийн үлдэгдэл нь 32,020.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,297.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 9,794.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 7,258.8 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шийдвэрийн дагуу шинэчлэн тогтоож, жилийн эцэст 265,605.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 61,294.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 41,618.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,120,734.5 мянган төгрөг, нийт зарлагыг 2,120,734.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 2,120,734.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аван, 1,981,837.9 мянган төгрөгийг зарцуулснаар гүйцэтгэл нь 93.4 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн шимтгэл, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, шуудан холбоо интернэт, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, багаж техник хэрэгсэл, дотоод томилолт, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж зэрэг зардлуудыг 138,896.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 10,541.3 мянган төгрөгийн нэмэлт орлого төвлөрүүлэн, дотоод албан томилолтын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,777,598.4 | 1,658,019.0 | 119,579.40 | 93.3% |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал | 1,485.0 | 1,485.0 | 0.00 | 100% |
| 80213 | Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс | 892.4 | 376.2 | 516.20 | 42.1% |
| 80219 | Харуул хамгаалалтын зардал | 1,800.0 | 1,800.0 | 0.00 | 100% |
| 80224 | Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн урамшуулал | 75,866.5 | 58,755.2 | 17,111.30 | 77.4% |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 252,431.9 | 250,742.3 | 1,689.60 | 99.3% |
| 80813 | Хуульд заасан үндэслэлээр | 2,256.3 | 2,256.3 | 0.00 | 100% |
| 80820 | Бусад тусламж, дэмжлэг | 8,404.0 | 8,403.8 | 0.20 | 99.9% |
| **НИЙТ** | | **2,120,734.5** | **1,981,837.9** | **138,896.6** | **93.4%** |

**Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар**

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгаан | 7,455.3 | 4,136.5 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалт | 45,383.5 | 42,539.3 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр, бохир ус | 2,591.8 | 2,429.6 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Тээвэр шатахуун | 3,500.0 | 3,500.0 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Шуудан, холбоо, интернэт | 2,687.0 | 2,429.9 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Хог хаягдал зайлуулах | 399.0 | 399.0 |
| 7 | Шууд худалдан авалт | Бичиг хэрэг | 8,456.0 | 8,448.9 |
| 8 | Шууд худалдан авалт | Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс | 6,604.3 | 6,213.9 |
| 9 | Шууд худалдан авалт | Багаж, техник, хэрэгсэл | 10,000.0 | 9,794.6 |
| 10 | Шууд худалдан авалт | Урсгал засвар | 9,350.0 | 9,350.0 |
| **ДҮН** | | | **96,426.9** | **89,241.7** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа , аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 03 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,181,496.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 32,722.4 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 25,041.5 мянган төгрөгийн зөрчилд 4 заалт зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж | 4 | 25,041.5 | 4 | 25,041.5 | 100% |
| Дүн | **4** | **25,041.5** | **4** | **25,041.5** | **100%** |

**5.Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

**5.2 Албан шаардлага хүргүүлээгүй.**

**5.3 Зөвлөмж өгөгдөөгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2025-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2025-02-22

АХЛАХ АУДИТОР Г.ЗАЯА ОГНОО: 2025-02-22

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2025-02-22